



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 89

Мандалговь

**Л.Баярсайханыг аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Лувсанням овогтой Баярсайхан 83.8 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Л.Баярсайханы холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

**ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ**



**Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшүүлсэн
Л.Баярсайханы тухай дүгнэлт**

1. Л.Баярсайхан нь 1969 онд Дундговь аймгийн Мандалговь хотод төрсөн. 53 настай, эрэгтэй
2. Боловсрол: 1996-1999 онд Цагдаагийн дээд сургуулийг бакалавр зэрэгтэй эрх зүйч мэргэжлээр, 2000-2002 онд Цагдаагийн академийг магистр зэрэгтэй, 2010-2011 онд Удирдлагын академийн төрийн удирдлагын менежерээр мэргэшүүлэх курсээр суралцаж төгссөн.
3. 1987-1990 онд Дундговь аймгийн Хүнсний үйлдвэрт ачигч, 1990-1994 онд Цагдаагийн хэлтсийн эргүүлийн цагдаа, 1994-1998 онд Цагдаагийн хэлтсийн паспортын бүртгэгч, 1998-2002 онд Цагдаагийн хэлтсийн эрүүгийн төлөөлөгч, 2002-2003 онд Цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч, 2003-2013 онд Цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, 2013-2014 онд Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, 2014-2021 онд Цагдаагийн газрын тасгийн даргын албан тушаалыг хашиж байгаад цэргийн тэтгэврээр өндөр настны тэтгэвэрт гарч, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн.
4. Л.Баярсайханы төрийн албаны дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

